



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/186/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 13</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Даваадорж</p> <p>Утас: 90119422 Цахим хаяг: Davaadorjd@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Албан шаардлага	16
5.2. Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

「**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА .ОЮУНДАЛАЙ ТАНАА**」

2026.02.24 № 2/37
танай _____-ны № _____-т

「**Өөрчлөлтгүй дүгнэлт**」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бөмбөгөр сумын ЭМТ-ийн даргын 2024 оны А/14 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан ёс зүйн дэд хороонд МУ-ын Ёс зүйн хорооны 2024.02.19-ний өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан ажиллах журмын 3.8 дахь заалтыг үндэслэн тайлант онд нийт 3,785.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2, мөн үндсэн ажлын хөлснөөс гадуур урамшуулал олгохыг хориглосон 10.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

6426050112

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн яамнаас баталсан төсөвт үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийг 326.4 сая төгрөгөөр зардлыг баталсан байхад ЭМД-ын сангийн 2025 оны үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийн квотод 282.3 сая төгрөгөөр төлөвлөсөн нь байгууллагын батлагдсан төсвөөс 44.1 сая төгрөгөөр бага байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн квот болон Эрүүл мэндийн яамнаас баталсан төсвийн хуваарь хоорондоо зөрүүтэй байсан нь төлөвлөсөн санхүүжилт бүрэн орж ирэх боломжийг хязгаарлаж тайлант онд өр үүсэх шалтгаан болсон байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ




2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>100,123,929.6</u>	<u>25,034,529.2</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	115,237.9	80,762.2
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	115,237.9	80,762.2
3121	Төгрөг	115,237.9	80,762.2
31211	Төрийн сангийн харилцах	115,237.9	80,762.2
33	АВЛАГА	68,314,934.2	3,293,793.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	784,703.9	784,703.9
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	67,530,230.3	2,509,089.2
34	УРЬДЧИЛГАА	9,004.0	9,004.0
3471	Урьдчилгаа тооцоо	9,004.0	9,004.0
34713	Цалингийн урьдчилгаа	9,004.0	9,004.0
35	БАРАА МАТЕРИАЛ	31,684,753.6	21,650,970.0
351	Түүхий эд материал	20,672,803.6	12,359,870.0
35110	Тусгай зориулалттай материал	9,252,694.0	9,253,870.1
35130	Эм боох материал	11,420,109.6	3,105,999.9
354	Хангамжийн материал	11,011,950.0	9,291,100.0
35410	Бичиг хэргийн материал	195,000.0	680,000.0
35420	Аж ахуйн материал	10,056,100.0	8,243,100.0
35460	Хүнсний материал	760,850.0	368,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>703,628,392.0</u>	<u>591,003,892.6</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	703,628,392.0	591,003,892.6
392	Биет хөрөнгө	674,596,392.1	562,054,392.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	492,903,921.0	523,243,921.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(119,882,213.8)	(160,342,594.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	178,247,625.0	170,587,625.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(67,769,140.7)	(95,331,047.1)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	416,720,607.0	322,433,019.1
39206	Хуримтлагдсан элэгдэл	(278,568,802.2)	(243,576,677.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,225,455.0	68,371,200.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,175,892.6)	(36,154,086.8)



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39214	Бусад үндсэн хөрөнгө	21,800,000.0	21,800,000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,516,666.6)	(10,716,666.8)
39217	Ном	1,611,500.0	1,739,700.0
393	Биет бус хөрөнгө	29,031,999.9	28,949,499.9
39301	Програм хангамж	890,000.0	890,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(670,000.1)	(752,500.1)
39303	Бусад биет бус хөрөнгө	28,812,000.0	28,812,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>803,752,321.6</u>	<u>616,038,421.8</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>86,806,319.2</u>	<u>52,897,017.9</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,806,319.2	52,897,017.9
413	Өглөг	86,806,319.2	52,897,017.9
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	52,075,305.2	37,664,464.8
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	34,079,814.0	11,755,553.1
4136	Бусад өглөг	651,200.0	3,477,000.0
41361	Байгууллагад төлөх өглөг	651,200.0	1,671,000.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,806,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>716,946,002.4</u>	<u>563,141,403.9</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	716,946,002.4	563,141,403.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	326,681,036.0	326,681,036.0
51101	Өмч: - төрийн	326,681,036.0	326,681,036.0
512	Хуримтлагдсан үр дүн	258,482,019.8	104,677,421.3
51210	Өмнөх үеийн үр дүн	258,482,019.8	258,482,019.8
51220	Тайлант үеийн үр дүн	-	(153,804,598.5)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,782,946.6	131,782,946.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>803,752,321.6</u>	<u>616,038,421.8</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,498,714,359.0	1,320,656,484.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	372,015,915.0	12,651,939.1
120	Нийтлэг татварын бус орлого	372,015,915.0	12,651,939.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,803,990.0	3,591,563.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,990.0	00.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,800,000.0	3,591,563.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,126,698,444.0	1,308,004,545.6
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,650,000.0	83,304,500.0



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,650,000.0	83,304,500.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,054,048,444.0	1,224,700,045.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,054,048,444.0	1,224,700,045.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,315,740,011.7	1,474,461,083.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,315,740,011.7	1,474,461,083.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,315,548,993.7	1,474,458,083.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,130,682.0	856,484,345.3
210101	Үндсэн цалин	459,787,367.0	505,264,733.3
210102	Нэмэгдэл	214,508,185.0	284,692,662.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,068,800.0	24,179,900.0
210104	Урамшуулал	47,766,330.0	42,347,050.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,410,445.7	105,379,769.5
210201	Тэтгэврийн даатгал	62,285,340.4	71,205,284.6
210202	Тэтгэмжийн даатгал	7,223,706.8	9,309,237.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,155,878.7	4,920,801.4
210204	Ажилгүйдлийн даатгал	3,530,062.2	3,951,367.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,215,457.6	15,993,078.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,812,282.0	43,816,904.7
210301	Гэрэл, цахилгаан	4,192,282.0	3,651,189.7
210302	Түлш, халаалт	37,620,000.0	40,165,715.0
2104	Хангамж, бараа материалын зардал	88,311,179.2	102,557,563.7
210401	Бичиг хэрэг	7,550,750.0	10,248,200.0
210402	Тээвэр, шатахуун	38,341,940.0	57,910,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.0	1,932,097.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,714,700.0	4,948,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,188,000.0	10,126,890.0
210408	Бараа материал акалсны зардал	21,535,789.2	17,391,676.7
2105	Нормативт зардал	176,963,459.8	163,493,548.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,052,979.8	134,557,198.6
210502	Хоол, хүнс	27,820,480.0	26,262,350.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,090,000.0	2,674,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,248,700.0	17,091,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	602,000.0	00.0
210604	Урсгал засвар	31,646,700.0	17,091,600.0
2107	Томилолт, зочны зардал	4,350,000.0	2,850,000.0
210702	Дотоод албан томилолт	4,350,000.0	2,850,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,406,319.0	5,149,764.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,671,259.0	2,510,200.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	96,700.0	871,200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,800.0	410,188.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,500.0	66,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	664,000.0	1,165,000.0
210807	Газрын төлбөр	49,060.0	126,676.0



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,915,926.0	177,634,587.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,852,900.0	12,505,788.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,063,026.0	165,128,799.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,018.0	3,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	191,018.0	3,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	191,018.0	3,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	182,974,347.3	-153,804,598.5
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	182,974,347.3	-153,804,598.5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,143,900,702.7	1,376,617,249.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,803,990.0	3,591,563.0
120	Нийтлэг татварын бус орлого	53,803,990.0	3,591,563.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,803,990.0	3,591,563.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,990.0	00.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,800,000.0	3,591,563.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,090,096,712.7	1,373,025,686.7
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,650,000.0	83,304,500.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,650,000.0	83,304,500.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,017,446,712.7	1,289,721,186.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,017,446,712.7	1,289,721,186.7
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,124,736,778.2	1,332,577,525.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,124,736,778.2	1,332,577,525.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,124,545,760.2	1,332,574,525.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	688,041,993.2	867,189,155.2
210101	Үндсэн цалин	408,847,831.3	481,485,440.8
210102	Нэмэгдэл	181,033,612.0	269,131,100.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,587,300.0	23,501,414.0
210104	Урамшуулал	91,573,249.9	93,071,200.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,308,400.0	109,085,800.0
210201	Тэтгэврийн даатгал	62,131,400.0	73,336,100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,544,300.0	8,937,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,035,400.0	4,468,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,509,000.0	4,468,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,088,300.0	17,874,900.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,312,282.0	43,301,500.0
210301	Гэрэл, цахилгаан	4,192,282.0	4,000,000.0
210302	Түлш, халаалт	37,620,000.0	38,804,500.0
210303	Цэвэр, бохир ус	500,000.0	497,000.0



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2104	Хангамж, бараа материалын зардал	65,768,750.0	81,657,200.0
210401	Бичиг хэрэг	5,489,850.0	7,330,200.0
210402	Тээвэр, шатахуун	36,458,000.0	57,242,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,815,000.0	1,658,900.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,565,000.0	6,927,800.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,440,900.0	8,498,300.0
2105	Нормативт зардал	175,942,960.0	191,672,631.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,060,630.0	158,467,231.2
210502	Хоол, хүнс	29,382,330.0	26,706,400.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,000.0	6,499,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,476,700.0	16,000,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,830,000.0	00.0
210604	Урсгал засвар	31,646,700.0	16,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,350,000.0	2,850,000.0
210702	Дотоод албан томилолт	4,350,000.0	2,850,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,011,319.0	5,260,561.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,751,259.0	2,469,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	96,700.0	750,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,800.0	405,864.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,500.0	47,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,189,000.0	1,438,197.0
210807	Газрын төлбөр	49,060.0	150,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,333,356.0	15,557,678.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,333,356.0	15,557,678.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,018.0	3,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	191,018.0	3,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	191,018.0	3,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,163,924.5	44,039,724.3
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,131,980.0	44,074,200.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,131,980.0	44,074,200.0
2200	Дотоод эх үүсвэрээр	19,131,980.0	44,074,200.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,131,980.0	44,074,200.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,131,980.0	-44,074,200.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,944.5	-34,475.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,293.4	115,237.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	115,237.9	80,762.2

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,195,036.00	56,224,214.00	-61,686,867.00	00.00	310,732,383.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,195,036.00	56,224,214.00	-61,686,867.00	00.00	310,732,383.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,943,877.14	00.00	-8,943,877.14
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	258,482,019.78	00.00	716,946,002.42
D01	2025 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	258,482,019.78	00.00	716,946,002.42
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	258,482,019.78	00.00	716,946,002.42
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-153,804,598.53	00.00	-153,804,598.53
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	104,677,421.25	00.00	563,141,403.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,342,811,100.00	1,293,312,749.71	49,498,350.29	96.31
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,591,563.00	(3,591,563.00)	-
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,016,603,500.00	976,274,955.20	40,328,544.80	96.03
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	903,939,900.00	867,189,155.20	36,750,744.80	95.93
Үндсэн цалин	565,205,600.00	481,485,440.76	83,720,159.24	85.19
Нэмэгдэл	238,667,100.00	269,131,100.44	(30,464,000.44)	112.8
Унаа хоолны хөнгөлөлт	6,996,000.00	23,501,414.00	(16,505,414.00)	335.9
Урамшуулал	93,071,200.00	93,071,200.00	-	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,663,600.00	109,085,800.00	3,577,800.00	96.82
Тэтгэврийн даатгал	75,769,000.00	73,336,100.00	2,432,900.00	96.79
Тэтгэмжийн даатгал	9,223,600.00	8,937,400.00	286,200.00	96.9
ҮОМШӨ-ний даатгал	4,611,800.00	4,468,700.00	143,100.00	96.9
Ажилгүйдлийн даатгал	4,611,800.00	4,468,700.00	143,100.00	96.9
Эрүүл мэндийн даатгал	18,447,400.00	17,874,900.00	572,500.00	96.9
Бараа, үйлчилгээний урсгал зардал	329,914,500.00	317,072,270.20	12,842,229.80	96.11
Хангамж, бараа материалын зардал	82,319,700.00	81,785,400.00	534,300.00	99.35
Бичиг хэрэг	7,527,500.00	7,380,200.00	147,300.00	98.04
Тээвэр, шатахуун	57,368,700.00	57,242,000.00	126,700.00	99.78
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,737,100.00	1,737,100.00	-	100



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,186,400.00	6,927,800.00	258,600.00	96.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,500,000.00	8,498,300.00	1,700.00	99.98
Нормативт зардал	202,876,300.00	191,672,631.20	11,203,668.80	94.48
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	169,669,800.00	158,467,231.20	11,202,568.80	93.4
Хоол, хүнс	26,706,400.00	26,706,400.00	-	100
Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,100.00	6,499,000.00	1,100.00	99.98
Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	19,946,000.00	54,000.00	99.73
Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,946,000.00	54,000.00	99.73
Томилолт, зочны зардал	3,500,000.00	2,850,000.00	650,000.00	81.43
Дотоод албан томилолт	3,500,000.00	2,850,000.00	650,000.00	81.43
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,655,700.00	5,260,561.00	395,139.00	93.01
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,823,100.00	2,469,000.00	354,100.00	87.46
Даатгалын үйлчилгээ	750,000.00	750,000.00	-	100
Тээврийн хэрэгслийн татвар	430,000.00	405,864.00	24,136.00	94.39
Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	47,500.00	7,500.00	86.36
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,447,600.00	1,438,197.00	9,403.00	99.35
Газрын төлбөр	150,000.00	150,000.00	-	100
Бараа үйлчилгээний бусад зардал	15,562,800.00	15,557,678.00	5,122.00	99.97
Бараа үйлчилгээний бусад зардал	15,562,800.00	15,557,678.00	5,122.00	99.97
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,346,518,000.00	1,293,347,225.40	53,170,774.60	96.05
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	115,237.90	115,237.85	0.05	100
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	80,762.2	(80,762.16)	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100
Үйлчлэх ажилтан	5	5	-	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлэх хүрээний хүн амд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг орчин үеийн эмчилгээ оношилгооны стандартад нийцүүлэн, жигд, чанартай, хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх зан үйлийг эзэмшүүлснээр хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эх нялхсын өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газраас тус байгууллагад хяналт, шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд


Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187,713.9 мянган төгрөг буюу 23.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	115.2	80.8	(34.5)
Авлага	68,314.9	3,293.8	(65,021.1)
Бараа материал	31,684.8	21,651.0	(10,033.8)
Үндсэн хөрөнгө	703,628.4	591,003.9	(112,624.5)
Хуримтлагдсан элэгдэл	(516,582.7)	(546,873.6)	(30,290.9)
Нийт хөрөнгө	803,752.3	616,038.4	(187,713.9)
Өр төлбөр	86,806.3	52,897.0	(33,909.3)



Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	716,946.0	563,141.4	(153,804.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	803,752.3	616,038.4	(187,713.9)

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн данс 80.8 мянган төгрөг болж өмнөх оноос 34.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 3,293.8 мянган төгрөг болж 65,021.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд өнгөрсөн оны Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 67,530.2 мянган төгрөгийн авлага барагдаж эрүүл мэндийн даатгалын сангаас шинээр 2,509.1 мянган төгрөгийн авлага үүссэн нь авлага данс буурхад голлох нөлөө үзүүлсэн байна. Харин хувь хүнээс авах 787.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21,651.0 мянган төгрөг болж 10,033.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн хөрөнгөөр 284,442.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 630.3 мянган төгрөгийн тусгай зориулалт, эм боох материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 277,567.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 17,539.6 мянган төгрөгийн бараа материал акталж устгасан нь бараа материалын данс буурахад голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 591,003.9 мянган төгрөг болж 112,624.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн хөрөнгөөр 13,684.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 5/31 дугаар тогтоол, аймгийн ЭМТ-ийн даргын 2025 оны А/81 дугаар тушаалын дагуу 8,480.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Мөн 30,340.0 мянган төгрөгийн урсгал засварын ажил хийгдэж, сайжруулалтаар орлогоор бүртгэсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 7/42 дугаар тогтоолоор нийт 134,837.9 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж данс бүртгэлээс хассан нь тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн дансны бууралтад голлон нөлөөлсөн байна

Өр төлбөрийн дансны үлдэгдэл тайлант хугацааны эцэст 52,987.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 33,909.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант хугацаанд өмнөх оны НДШ, ХХОАТ болон эмийн өглөгийн үлдэгдэл нийт 38,347.7 мянган төгрөгөөр буурсан нь өр төлбөрийн бууралтад голлох нөлөө үзүүлжээ.

Харин тайлант хугацаанд байгууллагын төлөх тогтмол зардал болон хувь хүнд өгөх өглөгийн хэмжээ нийлээд 4,432.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Эдгээр өглөгүүд нь оны эцэст санхүүжилтийн эрх нээгдээгүй зэрэг шалтгаанаар



үлдэгдэлтэй гарсан бөгөөд холбогдох байгууллага болон сумын Санхүү, төрийн сантай тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна..

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 563,141.4 мянган төгрөг болж 153,804.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үр дүн (153,804.6) мянган төгрөгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,574,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,574,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 227,482.0 мянган төгрөгөөр бууруулж өсгөж 1,346,518.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,189,721.2 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 3,591.6 мянга, нийт 1,293,312.7 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,293,347.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,293,347.2 мянган төгрөг буюу 96.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 36,750.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3,577.8 мянга, норматив зардал 11,203.7 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 83,301.5 мянган төгрөгийн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон урсгал засварын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80302 нэг иргэнд нормативаар	948,851.4	925,021.4	23,830.0	97.5%
2	81603 үндсэн мэрэгжлийн тусламж үйлчилгээ	326,429.5	297,169.6	29,259.9	91%
3	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	71,121.9	71,121.8	0.1	100%
4	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	83,304.5	83,301.5	3.0	100%
	Нийт дүн	1,429,707.3	1,376,614.2	53,093.1	96.3%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

1. Тус байгууллага нь хоолны хөнгөлөлт нэг өдөр 5.0 мянган төгрөгөөр тооцож унаа хоолны хөнгөлөлтөд 6,996.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 23,501.4 мянган төгрөгийг зарцуулсан нь цалингийн сандаа багтаан зарцуулсан байна.
2. Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.
3. Бүтэц орон тоог Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар 27 орон тоог баталсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 24.5 орон тоо ажиллаж орон тооны цомхотгол хийгээгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/39 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюундалай, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Гандалай нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 1,346,518.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,465.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 8,752.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Тухайн байгууллага нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсвийн 96.3 хувийг зарцуулж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 62,335.4 мянган төгрөгийн 9 гүйлгээ, орлогын 1,322,369.1 мянган төгрөгийн 44 мэдээг мэдээлэхээс 1,309,226.6 мянган төгрөг мэдээлж 13,142.5 сая төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн мэдээлүүлсэн. Мөн тайлант онд нийт 38 тушаал шийдвэрийг мэдээлэхээс шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитаар 4,694.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч зөрчлийг тайлант хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг өгсөн. Үүнд:

- Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025.01.31-ны өдрийн 11 дугаар тогтоолоор "Буянт Сэрвэн" ХХК-ний эзэмшлийн дулаанаар түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний төсөвт байгууллагад борлуулах эзлэхүүнээр тооцох тарифыг шинэчлэн тогтоосон байна. Тус тогтоолын 2 дах заалтад "Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд"-нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй." гэж заасан ба ЗХХАЭ-д 2025.02.01-д нийтлэгдсэн байхад 2025 оны 01 дүгээр сарын 1-ний эхлэн шинэ тарифаар гэрээ байгуулан 768.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн тул 2025 оны 12 сарын халаалтын санхүүжилтээс суутган тооцсон байна.
- Барилгын засвар дансанд Био 00 суултуур, галын сараалж төсөр, усалгааны төхөөрөмж, усны сав зэрэг аж ахуйн шинжтэй хөрөнгүүдийг бүртгэсэн байсан ба 2025 оны 12 сарын 31-ны байдлаар тайланд залруулга хийж бүртгэсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг "Баянхонгор аймаг дахь Төрийн аудит"-ын газрын аудитор Д.Эрдэнэбулган хийж гүйцэтгэсэн байна. Аудитаар Шилэн дансны цахим хуудсанд орлогын мэдээллийг дутуу оруулсан 54,947.4 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Хувь	
				Дүн	
Албан шаардлага	1	54,947.4	1	54,947.4	100
Нийт дүн	1	54,947.4	1	54,947.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан боловч Эрүүл мэндийн даатгалын сангийн квот болон Эрүүл мэндийн яамнаас баталсан төсвийн хуваарийн хооронд зөрүү үүссэн нь төлөвлөсөн санхүүжилт бүрэн орж ирэхэд нөлөөлж, улмаар тайлант онд өр үүсэх нөхцөл болсон байна.

Эрүүл мэндийн яамнаас баталсан тайлант оны төсвийн хуваарьт үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийг 326.4 сая төгрөгөөр тусгасан бол ЭМД-ын сангийн 2025 оны үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилтийн квотод 282.3 сая төгрөгөөр батлагдсан нь байгууллагын батлагдсан төсвөөс 44.1 сая төгрөгөөр бага байна. Тайлант онд байгууллага ЭМД-ын санд үндсэн тусламж үйлчилгээний 292.9

сая төгрөгийн санхүүжилтийн нэхэмжлэл илгээж, үүнээс 284.0 сая төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд ЭМД-ын тогтоосон квотоос давсан 7.7 сая төгрөгийн нэхэмжлэлийг Эрүүл мэндийн байцаагчийн хяналтаар хассан байна.

Эдгээр нөхцөл байдал нь санхүүжилтийн төлөвлөлт, ЭМД-ын сангийн квот тогтоолт болон батлагдсан төсвийн уялдаа холбоог сайжруулах хэрэгцээтэйг харуулж байгаа бөгөөд энэ асуудлыг дараагийн аудитаар анхаарч авч шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,173.4 мянган төгрөгийн нэг зөрчил¹ илэрсэнд зөрчлийг арилгах 4,173.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 4,173.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,579.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны А/14 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан Молгол улсын Ёс зүйн хорооны 2024.02.19-ний өдөр 5 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 3.8 "5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно. 3 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг улирал тутамд олгоно" гэсэн заалтыг үндэслэн ёс зүйн дэд хорооны гишүүдэд тайлант онд 3,785.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2."Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 10.2 "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ёс зүйн хорооны гишүүдэд олгосон 3,785.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв

5.1.2 Няравын тайланд шатахууны баримтыг жолоочийн замын хуудас болон зарцуулалтын тооцоотой тулган баталгаажаагүй 388.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. 2025 оны 9-р сард Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан тэмцээнд оролцох зорилгоор хувийн автомашинд 82.7 мянган төгрөгийн шатахуун олгосон боловч жолоочийн замын хуудас хөтлөөгүй бөгөөд шатахууны зарцуулалтын тооцоо бодоогүй байна.

2. 2025 оны 4-р сард алсын дуудлагад зориулан 30 литр дизель түлш олгосон боловч мөн адил жолоочийн замын хуудас хөтлөөгүй, шатахууны зарцуулалтын тооцоо хийгдээгүй байна.

3. 2025 оны 11-р сард жолоочид 132.0 мянган төгрөгийн 40 литр шатахуун олгосон боловч уг шатахууныг ямар зорилгоор, хаашаа зорчиж ашигласан нь тодорхой бус, жолоочийн замын хуудас хөтлөлгүй, тооцоо бодолгүйгээр олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй 388.4 мянган төгрөгийн гүйлгээний баримтын зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд тайлант онд 3,785.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	3,785.0	-	-	1	3,785.0	-	-
Шатахууны баримт тооцоо бодсон баримт, жолоочийн замын хуудсаар тооцоо бодоогүй 388.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	1	388.4	-	-	1	388.4	-	-
Нийт дүн	2	4,173.4			2	4,173.4		

-----oOo-----





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 77/А0571288/БМА-2026/186
НА-СТА-ТШС.

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны А/14 дугаар тушаалаар байгууллагын Ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд тайлант онд гишүүдэд 3,785,000 (Гурван сая долоон зуун наян таван мянга) төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2."Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 10.2 "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ёс зүйн хорооны гишүүдэд цалингийн цалингийн зардлаас урамшуулал олгодог байдлыг таслан зогсоож, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн,

6426030244

хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Оюундалай, нягтлан бодогч Ж.Гандалай нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Д.ДАВААДОРЖ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 77/АДСГ/2025/БНА-2026/186
ИД-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Няравын тайланд шатахууны баримтыг жолоочийн замын хуудас болон зарцуулалтын тооцоотой тулган баталгаажаагүй 388,400 (Гурван зуун наян найман мянга дөрвөн зуун) төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтгүй 388,400 (гурван зуун наян найман мянга дөрвөн зуун) төгрөгийн гүйлгээний баримтын зөрчлийг арилган, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Оюундалай, нягтлан бодогч Ж.Гандалай нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Д.ДАВААДОРЖ



² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно